

## ЭВСЭЛД ҮЛ НЭГДЭХ ХӨДӨЛГӨӨН БОЛ ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ЧУХАЛ ХҮЧИН ЗҮЙЛ МӨН

Л. Хайсандай

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний албан ёсны түүх нь дөнгөж 20 гаруй жил болж байгаа боловч хэн ч хайхрахгүй байхын аргагүй олон улсын томоохон хүч болж, энх тайван, үндэсний эрх чөлөө, дэвшил хөгжлийн төлөө империализм, түрэмгийлэл, колоничлол шинэ колоничлолын эсрэг улс түмний хамтын тэмцлийн үйлсэд үлэмж эерэг хувь нэмэр оруулсаар байна.

Дэлхийн хоёрдугаар дайнд социализм, дэвшил ардчилалын талынхан ялж социалист улсуудын гэр бүл үүсэн тогтож, өсөж бэхжисний үрээр колоничлолын бурангуй систем задран унаж, улс түмний эрх чөлөөний тэмцэл өрнөн, Ази ба Африкт олон арван улс тусгаар тогтносон юм. Тэр үед ноёрхлын нь хүрээ тийнхүү хумигдаж, байр сууриа ихэд алдсан империалист харгис хүчнүүд «хүйтэн дайны» бодлого баримталж, социализмын эсрэг тэмцэх, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг нухчин дарах зорилгоор НАТО, СЕНТО, СЕАТО зэрэг цэргийн түрэмгий эвслүүдийг эмхлэн байгуулж, түүндээ шинэ тулгар тусгаар тогтносон улс орнуудыг татан оруулах гэж элдвээр оролдох болсон билээ. Ийм нөхцөлд Ази, Африкийн чөлөөлөгдсөн орнууд өөрсдийн гадаад бодлогын үндсэн зарчим, чиг шугамыг «нааштай төвийг сахих», «эвсэлд нэгдэн орохгүй байх» гэж томъёолон тунхаглаж, түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд хүч чармайлт, үйл ажиллагаагаа нэгтгэж хамтран тэмцэхийг гол зорилго болгожээ. Энэ нь 1955 оны Бандүнгийн бага хурлын үзэл санаа, түүхэн шийдвэрт жинхэнэ тусгалаа олсон юм. Тийнхүү социалист орнуудын эсрэг чиглэсэн империалист цэргийн аливаа эвсэл бүлэглэлд нэгдэн орохоос татгалзах үзэл санааны дор эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний эхлэл анх тавигджээ.

Хорь гаруй жилийн өмнө, 1961 оны есдүгээр сард Белград хотноо эвсэлд нэгдээгүй улс орны төр, засгийн газрын тэргүүн нарын анхдугаар бага хурал хуралдсан нь эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зохион байгуулалтын хувьд төлөвшин тогтох болсон билээ.

Уг хөдөлгөөн ямар чиг баримжаа цаашид барих, юуг гол болгон ажиллахаар төлөвлөж байгааг эвсэлд нэгдээгүй улс орны анхдугаар бага хурлаар баталсан тунхаглалд «одоо үед аль ч улс, ямар ч засгийн газар даян дэлхийн энх тайвны төлөө хариуцлага хүлээхээс зайлж чадахгүй», «колоничлол, империализм, шинэ колоничлолын бүхий л илрэлийг бүрмөсөн устгасан цагт л... бат энх тайван байдлыг хангаж болно», «улс түмний хоорондын дайн бол ёсноос гажуу үзэгдэл төдий бус, хүн төрөлхтний эсрэг хандсан ялт хэрэг мөн», «энх тайвнаар зэрэгцэн орших зарчим бол «хүйтэн дайн» хийгээд бүх нийтийн цөмийн болзошгүй сүйрлийн өөдөөс сэргөөх цорын ганц зам мөн»<sup>1</sup> гэж тодорхойлсон байна.

Мөн ийм зорилго чиглэлийг эвсэлд нэгдээгүй улс орны бусад чуулга уулзалтын баримт бичиг ч гэрчлэн харуулж байна. Жишээлбэл, 1964 онд Кайрт болсон эвсэлд нэгдээгүй улсуудын II бага хурлаар баталсан баримт бичигт тэмдэглэхдээ: «Империализм, колоницлол, шинэ колоницлол бол дэлхий дахины энх тайван, аюулгүй байдалд заналхийлж байдаг учир олон улсын түгшүүртэй байдал, зөрчил мөргөлдөөний гол уг сурвалж мөн»<sup>2</sup> гэжээ. III бага хурлын (Лусака, 1970 он) баримт бичигт ч мөн иймэрхүү үндэслэл орсон байна.

IV бага хурлын (Алжир, 1973 он) улс төрийн тунхаглалд заахдаа «Эдүгээ Өрнө, Дорнын хоорондын харилцааны түгшүүртэй байдлыг сулруулахад олсон амжилт, түүнчлэн Европт дэлхийн хоёрдугаар дайны үеэс уламжилж үлдсэн асуудлыг зохицуулах үйлсэд олсон амжилт бол даян дэлхийн энх тайвны хүчний чухал ялалт мөн»<sup>3</sup> гэжээ. Алжирын бага хурал энэ хөдөлгөөний түүхнээ анх удаа олон улсын эдийн засгийн харилцааг тэгш эрх, шударга ёсны үндсэн дээр өөрчлөн зохиох шаардлага дэвшүүлжээ.

V бага хурал (Коломбо, 1976 он) улс төрийн тунхаглалдаа «эвсэлд үл нэгдэх бодлого олон улсын байдлыг өөрчлөхөд улам их нөлөөлж байна»<sup>4</sup> гэж тэмдэглэжээ. Уг баримт бичигт «Олон улсын түгшүүртэй байдлыг намжаахад дэвшил гарсныг» баяртай тэмдэглээд «Зэвсэг хураах асуудлаар Дэлхий дахины бага хурал хуралдуулах үр ашигтай арга хэмжээг хойшлуулалгүй авах нь чухал»<sup>5</sup> гэж цохон тэмдэглэжээ.

VI бага хурлын (Гавана, 1979 он) гол үр дүн нь улс төр, эдийн засгийн хоёр хэсгээс бүрэлдсэн төгсгөлийн тунхаглал болов.

Улс төрийн хэсэгт нь орчин үеийн нөхцөлд «Энх тайван зэрэгцэн орших зарчим олон улсын харилцааны гол тулгуур байх ёстой»<sup>6</sup> гэдгийг нотлоод өмнөд Африк, Ойрхи Дорнод, Зүүн өмнөд Ази, Төв Америкт түгшүүртэй байдал өсөн нэмэгдэж, энх тайван байдалд аюул занал учирч байгааг<sup>7</sup> заасан байна. Энэ нь империализм болон түүний хамсаатан, хамгийн харгис бүлгийнхний явуулж буй түрэмгий үйл ажиллагааны уршиг<sup>8</sup> бөгөөд дээрх бүс нутгуудад гагцхүү бүрэн эрхт байдал, шударга ёс тусгаар тогтнол сэргээн тогтоох, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс үл оролцох үндсэн дээр л энх амгалан, тогтвортой байдал ялан дийлж чадна<sup>9</sup> гэж Тунхаглалд тэмдэглэсэн байна.

VI бага хуралд оролцогчид дэлхийн эдийн засгийн хөгжлийг авч хэлэлцээд хөгжиж байгаа улс орны өмнө тулгарч буй асуудал улам бүр хурцдаж байгаа явдалд сэтгэл ихэд түгшиж байгаагаа илэрхийлэв. Тунхаглалын эдийн засгийн хэсэгт өгүүлэхдээ тухайлбал «орчин үеийн олон улсын эдийн засгийн системийн шударга биш байдлыг арилгахын төлөө, олон улсын эдийн засгийн шинэ журам тогтоохын төлөө тэмцэл бол улс төр, эдийн засаг, соёл, нийгмийн эрх чөлөөгөө олохын төлөө улс түмний тэмцлийн бүрэлдэхүүн хэсэг мөн»<sup>10</sup> гэжээ.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн үйл ажиллагаандаа хүн төрөлхтний дийлэнхи олонхийн эрхэмлэдэг энх тайван, нийгэм-эдийн засгийн дэвшил,

<sup>2</sup> «Движение неприсоединения в документах и материалах», М., 1979, 73 дахь тал.

<sup>3</sup> Мөн тэнд. 173 дахь тал.

<sup>4</sup> «Всемирное профсоюзное движение» 1976, № 9.

<sup>5</sup> Мөн тэнд.

<sup>6</sup> «Гранма», 1979, IX- 10.

<sup>7</sup> Мөн тэнд.

<sup>8</sup> Мөн тэнд.

<sup>9</sup> Мөн тэнд.

<sup>10</sup> Мөн тэнд.

тэгш эрх, хөндлөнгөөс үл оролцох харилцан ашигтай хамтран ажиллах зарчмыг удирдлага болгож байгааг VII бага хурал (Дели, 1983 он) бас дахин нотоллоо. Энх тайвныг бэхжүүлэх, цөмийн дайныг сэрэмжлэн зайлуулах, зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох, улс түмний эрх чөлөөтэй тусгаар тогтнон, нийгмийн дэвшлийн замаар замнах эрхийг бодитойгоор эдлүүлэх явдал бол тус хөдөлгөөний өмнө одоо тулгарч байгаа гол зорилт мөн гэсэн санаа энэ VII бага хурлын дүнгийн баримт бичгүүд болох улс төр, эдийн засгийн тунхаглалд зонхилж байна.

Улс төрийн тунхаглалд «гагцхүү зэвсгийг бүх нийтээр бүрэн хурааж, юуны өмнө цөмийн зэвсгийг хурааж, сөргөлдөх бодлогоос татгалзаж баймааж л олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангаж болно»<sup>11</sup> гэж цохон заагаад дэлхийн янз бүрийн бүс нутагт цөмийн зэвсэггүй бүс байгуулах явдалд баяр хүргэжээ.

Делийн бага хурал Ойрхи Дорнодын байдал эрс хурцадсанд сэтгэл ихэд зовниж байгаагаа илэрхийлээд 1967 онд эзлэгдсэн арабын бүх нутаг дэвсгэрээс израилийн цэргийг бүрмөсөн үг дуугүй гаргах, палестины араб ард түмний үндэсний салшгүй эрхийг эдлүүлсэн нөхцөлд л энэ бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг хангаж болно. Палестины араб ард түмний цорын ганц хууль ёсны төлөөлөгч бол Палестины чөлөөлөх байгууллага мөн<sup>12</sup> гэж дахин мэдэгдсэн нь улс төрийн чухал ач холбогдолтой юм.

Диего-Гарси арал дээр АНУ цэргийн баазаа өргөжүүлэн, Энэтхэгийн далайд цэргийн оролцоогоо шатлан нэмэгдүүлж байгааг эрс шийдвэртэй буруушааж, ийм ажил явууллага нь энэ бүс нутгийн улсуудад аюултайг баримт бичигт онцлон тэмдэглэжээ.

Апартеид бодлого, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах явдал, колоничлол ноёрхсоор байгаа Африкийн өмнөд нутгийн байдалд дүн шинжилгээ хийгээд, Преторийн арьсны үзэлт дэглэмтэй өрнөдийн хэд хэдэн орон, израиль хамсан ажиллаж байгааг баримт бичигт бас буруушаажээ.

Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлынхаа төлөө, империализм, колоничлол, гадаадынхны ноёрхлын эсрэг тэмцэж байгаа Латин Америкийн улс түмнийг дэмжиж байгаагаа Делийн чуулга уулзалт илэрхийлэв.

Одоо дэлхий дахинд мөрдөж байгаа эдийн засгийн харилцааны систем нь шинэ тулгар хөгжиж байгаа улсуудад үгээгүй хоосон байдал, өлсгөлөн, өвчин эмгэг, бичиг үсэг үл мэдэх явдлыг болон колоничлогчдын олон арван жилийн ноёрхол, мөлжлөгийн уршиг болсон нийгмийн бусад согогийг арилгахад саад болж байгааг<sup>13</sup> эдийн засгийн тунхаглалд онцлон тэмдэглэжээ.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн бага хурлаас бага хуралд өргөжин тэлж, бага хурлаас бага хуралд түүний тэмцэл, үйл ажиллагаа шинэ шинэ хэлбэрээр баяжин өрнөж ирсний нэг баталгаа бол уг хөдөлгөөний бүрэлдэхүүний тасралтгүй өсөлт юм. Эвсэлд нэгдээгүй орнуудын төр, засгийн тэргүүн нарын 1961 онд Белградад болсон анхдугаар бага хуралд зөвхөн 25 орон оролцож байсан бол 1964 онд Каирт болсон 2-р бага хуралд 47, 1970 онд Лусакад болсон 3-р бага хуралд 54, 1973 онд Алжирт болсон 4-р бага хуралд 76, 1976 онд Коломбод болсон 5-р бага хуралд 86 орон тус тус оролцож байв. 1979 онд Гаванад болсон 6-р бага хуралд Боливи, Гренада, Иран, Никарагуа, Палестины чөлөөлөх байгууллага, Суринам, Зимбабвейн эх оронч фронтыг энэ хөдөлгөөний бүрэн эрхт гишүүнээр, Филиппин, Сент-Люси, Доминика, Коста-Рика улсыг ажиглагчаар элсүүлснээр 97 орон болсон ба 1983 оны 3-р сард Делид

<sup>11</sup> «Үнэн» 1983. III. 13.

<sup>12</sup> Мөн тэнд.

<sup>13</sup> «Үнэн» 1983. III. 13.

болсон VII бага хурал Багамын арлуудын хамтын нөхөрлөл, Барбадос, Колумби, Вануату улсыг гишүүнээр элсүүлснээр уг хөдөлгөөний гишүүн орон 101 болж нэмэгдэв. Энэ нь НҮБ-ын бүх гишүүн орны гуравны хоёр болж байна.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд Африк тив хамгийн өргөн оролцож 49 орон нийлсэн байна. Тийнхүү ӨАБНУ-ын арьсны үзэлт дэглэмийг эс тооцвол Африкийг «эвсэлд нэгдээгүй тив» гэж нэрлэж болох билээ. Тэр тусмаа эвсэлд үл нэгдэх явдлыг Африкийн эв нэгдлийн байгууллагын Хартид нэг гол зарчим болгож албан ёсоор оруулсан байна.

1973 оны есдүгээр сард Чилид фашист эргэлт гарахаас өмнө энэ улс уг хөдөлгөөнд оролцогч орон байв. 1975 онд Лима хотноо болсон эвсэлд нэгдээгүй орнуудын гадаад явдлын яамны сайд нарын зөвлөлгөөн Чилид ардчилалыг хөсөрдүүлсэн Пиночетын фашист хунтыг эрс зэмлэн буруушаасан юм. Ингэснээр нь энэ хөдөлгөөнөөс Чилийн хунт аяндаа хасагдсан билээ.

Делийн бага хурал нь эвсэлд нэгдээгүй орнуудын түүхэнд урьд байгаагүй олон улс, төлөөлөгч оролцсон дээд хэмжээний чуулга уулзалт болсон бөгөөд уг нь тус бага хурлыг 1982 оны 9-р сард Багадад хийхээр төвлөсөн байсан боловч Иран-Иракийн дайны улмаас хагас жилээр хойшлуулан Энэтхэгийн нийслэлд бага хугацааны дотор шуурхай бэлтгэж амжилттай болж өнгөрлөө.

VII бага хурлаас эвсэлд нэгдээгүй орнуудын дараагийн гурван жилд ажиллах зохицуулах товчооны бүрэлдэхүүнд Азиас найм (Бангладеш, Вьетнам, Индонез, Ирак, Өмнөд Йемен, Сири Шри-Ланка, тэрчлэн Палестины чөлөөлөх байгууллага), Африкаас мөн найм (Алжир, Гана, Гвиней, Заир, Зимбабве, Коморын арал, Баруун өмнөд Африкийн ардын байгууллага), Латин Америкаас дөрөв (Боливи, Гренда, Никарагуа, Суринам), Европосс хоёр (Кипр, Мальта) улс тус тус сонгогдов. Зохицуулах товчооны дарга Энэтхэг улсын ерөнхий сайд Индира Ганди болов.

Эгнээндээ тийнхүү 100 гаруй улс орныг багтаасан эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн бүрэлдхүүнээрээ туйлын жигд биш, түүнд феодалын байгуулал бүхий хэмжээгүй эрхт хаант улс, капиталист хөгжлийн замаар явж байгаа улс орон, социалист чиг баримжаа бүхий улс орон, бас хэд хэдэн социалист улс (БНСВУ, БНАЛАУ, БНАСАУ, БНКУ, ХБНСЮУ) багтаж байгаа юм. Хөдөлгөөнд оролцогчдын нийгэм улс төрийн чиг баримжаа ялгаатайн улмаас шийдвэрлэвэл зохих асуудалдаа өөр өөр янзаар хандах явдал гардаг нь зүйн хэрэг юм. Эвсэлд нэгдээгүй улсууд «шинэ эвсэл байгуулахыг хүсэхгүй бөгөөд өөрөө эвсэл байж таарахгүй»<sup>14</sup> гэж бүр анхдугаар бага хурлаас тогтоосон юм. Гэтэл зарим бүлгийнхэн тиймэрхүү эвсэл байгуулах, түүнийгээ «хоёр хэт их гүрэн» гэгчийн өөдөөс чиглүүлэхийг зарим үед эрмэлзэж байв. Дэвшилт хүчин энэ хөдөлгөөнд ийм хагарал гаргахад чиглэсэн удаа дараагийн явууллагаас эвсэлд үл нэгдэх зарчмыг хамгаалах хэрэгтэй болж байлаа. Жишээ нь: 1978 оны зун Белградад болсон эвсэлд нэгдээгүй улс орны гадаад явдлын яамдын сайд нарын бага хурал Африкийн зарим улс оронд империалист түрэмгийллийг няцаахад нь Кубын үзүүлж байгаа интернационалч тусламжийн утга санааг гуйвуулан 1979 онд Гаванад хуралдуулахаар төлөвлөсөн VI бага хурлыг тасалдуулахыг оролдсон байна. Гэвч Латин Америкт анх удаа, социалист Кубад хуралдах бага хурлыг тасалдуулж чадаагүй юм. БНКУ бол энэ хөдөлгөөнийг үндэслэн байгуулагчдын нэг бөгөөд түүний эгнээнд зүй ёсоор өндөр нэр хүндтэй байгааг энэ удаагийн бага хурал дэлхийн нийтийн өмнө яруу тод харуулж өгсөн билээ.

<sup>14</sup> «Движение неприсоединения ...» М., 1979, 55 дахь тал.

Чухамдаа эвсэлд нэгдээгүй орнуудын талаар дэлхийд бүр эхнээсээ аваад нэг талаас социалист улсуудын чиг шугам, нөгөө талаас империалист гүрнүүдийн чиг шугам-ийм улс төрийн хоёр чиг шугам ил тод болсон билээ. Эвсэлд нэгдээгүй орнууд энхийг эрхэмлэсэн колоницлол, шинэ колоницлолыг эсэргүүцсэн программ дэвшүүлэн олон улсын улс төрийн тавцан дээр халитран гарч ирснийг социалист нөхөрлөлийн улсууд дэвшилт, ардчилсан нийт хүчний хамт тууштай дэмжин угтсан байна. Тэд энэ программыг хэрэгжүүлэхэд бүхий л талаар тус дөхөм болж, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний зарчим, үзэл санааг ойлгож, хүндэтгэн хандсан юм.

«Зөвлөлт Холбоот Улс байгаагүйсэн бол бага буурай орнуудын энэ хир тусгаар тогтноод байгааг, улс түмэн байгалийнхаа баялагт эзэл болох, өөрийн хяналт тогтоохын төлөө амжилттай тэмцэж байгааг, тэдний дуу хоолой бүх улс үндэстний нийтийн дуу хоолойтой хөг нийлэн сүртэй цуурайтаж байгааг төсөөлөн бодохын аргагүй билээ»<sup>15</sup> гэж Кубын удирдагч Фидель Кастро тодорхойлжээ.

Империалист хүчнүүд энэ шинэ хөдөлгөөнийг, тухайлбал түүнд оролцогчдын заримыг дэлхийг нийтэд нь эзлэн ноёрхох бодлогодоо, социализмыг эсэргүүцсэн тэмцэлдээ, коммунизмын эсрэг үзлийг тулган хүлээлгэхдээ ашиглахыг юун түрүүн эрмэлзсэн байна. Үүний тулд улс төрийн талаар сүрдүүлэх, эдийн засгийн талаар хавчин шахах, үзэл суртлын талаар нөлөөлөх гэж төрөл бүрээр оролдож, тэр ч байтугай янз янзын хуурамч «онол номлол» ч зохион гаргаж үзжээ. Тэдний зүгээс эвсэлд нэгдээгүй орнуудад дэлгэрүүлэхийг хичээж байгаа нэг номлолын ёсоор бол «эвсэлд үл нэгдэх үзэл нь капиталист хийгээд социалист улсуудын аль алинаас нь адилхан хол зайтай байх явдал юм». Гэтэл эвсэлд үл нэгдэх үзлийн гол утга санааг ингэж гуйвуулах явдлыг Ж. Неру, А. Насер, Б. Тито, С. Бандаранаике нарын зэрэг тус хөдөлгөөнийг үндэслэгч нэрт зүтгэлтнүүд эрс буруушааж няцааж байсан билээ. Тухайлбал Ж. Неру мэдэгдэхдээ: «Хаана эрх чөлөө, шударга ёс, аюул заналд өртөж байна тэр газар, хаана түрэмгийлэл үйлдэж байгаа тэр газар бүхэнд бид төвийг сахиж байж хэрхэвч чадахгүй»<sup>16</sup> гэжээ. Энэ нь уг хөдөлгөөний гол чиг шугам болж биеллээ олсоор байна. Империалистууд эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний доторхи улсуудын олон талын ялгаа зарим зөрөлдөөнийг ашиглан тэднийг социалист нөхөрлөлийн орнуудаас хөндийрүүлэх, бие биесийн нь өөдөөс сөргүүлэн тавих, улмаар уг хөдөлгөөний империализмыг эсэргүүцсэн үндсэн чиглэлийг нь өөрчлөн, зөв замаас нь гаргахыг олон жилийн турш оролдсоор байгаа юм. Үүний уршгаар империалист суртал нэвтрүүлгийн үр хөврөл эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний дотор зарим үе соёолж ч байв. Ийм байдал, шинж тэмдэг бүр 1973 онд Алжирын чуулга уулзалтын үеэс идэвхжсэн бөгөөд Коломбо, Гавана, Делийн бага хурал дээр ч илэрч байв. Жишээ нь Алжирын нийслэлд болсон чуулга уулзалт дээр зарим орны төлөөлөгч үг хэлэхдээ манай дэлхий ертөнц социалист ба капиталист систем болж хуваагдсан нийгмийн өнөөгийн үндсэн гол заагийг «баян, ядуу орон», «хөгжсөн умард, хоцрогдсон өмнөд» гэдэг өрнөдийн онолчдын томъёололоор солих гэж оролдоод үзжээ. Мөн зарим нь эвсэлд нэгдэхгүй байх явдлыг капиталист, социалист системийн аль алинаас нь хөндий байж, тэдгээрийг зааглаж байгаа маргаанд үл оролцох боломж, тэр ч байтугай шаардлага мөн гэж зүй зохисгүй тайлбарлажээ. Ер нь уг хөдөлгөөнд оролцогчдын зарим нь империализмыг эсэргүүцсэн үзэл бодло-

<sup>15</sup> «Правда» 1977. XI. 7.

<sup>16</sup> Дж. Неру Виешняя политика Индии. Избранные речи и выступления. 1946— 1964. М., 1965, 58 дахь тал.

гыг тийм ч хатуу тууштай баримтлахгүй байгаа, хөдөлгөөний дотоодод олон арван асуудлын талаар нэгдмэл үзэл байхгүй, улс төрийн туршлагаар ч харилцан адилгүй байгаа нь бараг бага хурал бүрийн явц байдал харуулж байна. Чухамхүү үүнээс болоод өнөөдөр шинэ тулгар хөгжиж байгаа орнуудын сая сая хүн ардын анхаарлыг татаж байгаа нийгмийн хөгжлийн замыг сонгох (капиталист буюу капиталист биш хөгжлийн алиныг сонгохыг хэлж байна Л. Х) мэтийн асуудал тус хөдөлгөөний дээд чуулга уулзалтын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд одоо болтол орохгүй байгаа билээ.

Сүүлийн үед эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний мөн чанар, хөдөлгөөнд элсэх шалгуурын тухай асуудлыг өргөн шүүмжлэн хэлэлцсэн байна. Жишээлбэл Коломбын бага хурал дээр уг шалгуурыг улам өргөтгөх санал дэвшүүлжээ. Энэ асуудалтай холбогдуулж Кубын төлөөлөгчдийн тэргүүний хэлсэн үг тун эрүүл зөв, үнэн бодитой цуурайтжээ. Түүний хэлсэн нь: «Хэрэв бид улс төрийн ёс суртахууны нэр хүндтэй байхыг хүсвэл тооны төлөө бус, чанарын төлөө санаа тавих хэрэгтэй. Гагцхүү ингэж байж хөдөлгөөнд шинэ шинэ хүчийг нэгтгэх нь манай нөлөө, манай улс төрийн хүч чадлыг үнэхээр нэмэгдүүлнэ... Түүнчлэн эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд гишүүн байх болзлыг зөвхөн цэргийн эвсэлд оролцоогүй байх явдлаар хязгаарлахгүй, бас ард түмэнд колонийн ба хагас колонийн боолчлолыг давж, хөгжил, өв тэгш аж байдлын замд орох бололцоо олгох өөрчлөн байгуулалтын программыг талархан үздэгээр нь тодорхойлдог байх ёстой»<sup>17</sup> гэжээ.

Чөлөөлөгдсөн орнууд социализмын ертөнцтэй олон талын хамтын ажиллагааг өргөжүүлж буй үйл явц бол манай өнөө үеийн хувьсгалт нэг хандлага мөн. Энэ хандлага шинэ тулгар улсуудын улс төр, эдийн засгийн нэгдэл батжихад тус болж, олон улсын үйл хэрэгт бие даан оролцох, бүрэн эрхээ сахин хамгаалах боломжийг тэдгээрт олгож байна.

Эвсэлд нэгдээгүй орнуудын хөдөлгөөн бодит социализмын хүч нөлөө, байнгын дэмжлэгийг хүлээн авч урагш ахихын хирээр империализмыг эсэргүүцсэн мөрийн хөтөлбөр нь улам ил тод болж, эдгээр улс орон дотоод гадаад бодолгодоо дэвшилт чиг баримжаа барих нь үлэмж нэмэгдэж байгаа билээ.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний үндсэн зарчим, үзэл санааг бүр анхнаас нь социалист монголын ард түмэн, БНМАУ-ын засгийн газар ЗХУ болон социализмын бусад орон, дэлхийн дэвшилт бүх хүчний нэгэн адил гуйвалтгүй дэмжиж байдаг юм.

Эвсэлд нэгдээгүй орнуудын төр, засгийн тэргүүн нарын VII бага хурлын даргад явуулсан илгээлтдээ БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю. Цэдэнбал «Орчин үеийн олон улсын амин чухал асуудлуудаар социалист орнууд, түүний дотор Бүгд Найрамдах Монгол Ард Улс болон эвсэлд нэгдээгүй орнуудын баримталж байгаа байр суурь адил буюу ойр төстэй байгааг тэмдэглэхэд таатай байна. Энх тайван аж төрж бие биедээ итгэж найрсгаар хамтран ажиллах явдал Монгол улсын гадаад бодлогын үйл ажиллагааны жанжин шугам юм. Чухамдаа ийм зарчимт чиг шугамынхаа үүднээс БНМАУ эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний үндсэн гол зарчмын нэг маргаантай асуудлыг шийдвэрлэхийн тулд хүч хэрэглэх буюу хүчээр заналхийлэхээс татгалзах явдлыг Ази, Номхон далайн орнуудын харилцаанд хуульчлан бататгахуйц олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулахын төлөө байна»<sup>18</sup> гэж тэмдэглэжээ.

<sup>17</sup> «Гранма», 1976. VIII. 16.

<sup>18</sup> «Үнэн» 1983. III. 18.

Гагцхүү энх тайван нөхцөлд л жинхэнэ тусгаар тогтнолоо олж, дэвшил хөгжилд хүрч чадна гэсэн санааг эвсэлд нэгдээгүй орнуудын ээлжит бүх бага хурал, түүний дотор Делигийн дээд хэмжээний чуулга уулзалт чухалчлан дэвшүүлжээ. Дайсагнагч хүчний зүгээс хорт явуулга үйлдэж, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний нэр хүндийг гутаах гэж оролдсон боловч VII бага хурал амжилттай болж, дэлхий дахины болон Азийн аюулгүй байдлыг хангах, эвсэлд нэгдээгүй орнуудын хамтын ажиллагаа, эв нэгдэл, хүч чармайлтыг нэгтгэн бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулав. Чухамдаа эвсэлд үл нэгдэх үзэл санаа анх Энэтхэг улсад үүссэн бөгөөд эдүгээ олон улс оронд түгэн дэлгэрч томоохон хөдөлгөөн болж өрнөөд олон улсын харилцааны чухал хүчин зүйл болжээ.

Одоо үед хүн төрөлхтөний сайн сайханд төдийгүй бас хойч үеийнхэнд аюул занал учруулж байгаа цөмийн мөргөлдөөн рүү гулсч байгаа явдлыг юуны түрүүн нэн даруй эцэс болгохыг эвсэлд нэгдээгүй орнууд эрс шийдвэртэй уриалж байна. «Манай дэлхийн хэмжээ хязгаартай материаллаг нөөцийг улам их залгиж, экологийн тэнцвэрийг алдагдуулж, манай шинжлэх ухааны зүтгэлтнүүдийн шилдэг авьяасыг огт хэрэгцээгүй, эвдэн сүйтгэх зорилгод ашиглаж байгаа зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зогсоох хэрэгтэй. Дэлхий бол бид бүхний гэр орон юм. Тийм учраас эв найрамдалтай, хүн төрөлхтний нэр сүр, хүмүүсийн тэгш эрхэнд үндэслэсэн жинхэнэ ах дүүсийн барилдалгаатай байж эх дэлхийгээ хамгаалцгаая»<sup>19</sup> гэж Делигийн уриалгад өгүүлсэн нь өнөөдөр улам ч сүр хүчтэй цуурайтан байна. Энэ бол зөвхөн эвсэлд нэгдээгүй орнуудын ард түмний уриа төдийгүй манай гаригийн бүх дэвшилт шударга улс түмний чин эрмэлзэл итгэлийн уриа мөн.

## ДВИЖЕНИЕ НЕПРИСОЕДИНЕНИЯ-ВАЖНЫЙ ФАКТОР МЕЖДУНАРОДНЫХ ОТНОШЕНИЙ

### ( Р е з ю м е )

Эволюция международных отношений современного мира тесно связана с влиянием и активностью неприсоединившихся стран, с ориентацией их политики. Выступившие широким фронтом на мировую арену после распада колониальной системы, неприсоединившиеся страны все более активно подключаются к борьбе за мир, против агрессии и эксплуатации, за создание необходимых условий их успешного развития. В этой борьбе укрепляется авторитет движения неприсоединения, все более значительным становится его место во всей системе современных международных отношений. Так, если в первой конференции глав государств и правительств неприсоединившихся стран (1961. Белград) участвовали 25 стран, то в седьмой конференции на высшем уровне, проходившей в марте с. г. в Дели, собрались руководители более 100 стран, что составляет две трети всех членов ООН. Таким образом, движение неприсоединения крепло от конференции к конференции и от конференции к конференции становилось все более четким позитивное содержание борьбы неприсоединивших-

с государств. Начиная с 70-х годов, происходит превращение его во влиятельный фактор международной жизни.

Отмечая позитивные черты и тенденцию развития движения неприсоединения, нельзя, однако, пройти мимо тех особых проблем, с которыми оно сталкивается. В рядах его есть социалистические государства и страны социалистической ориентации, буржуазно-демократические республики и феодальные монархии, есть и военные диктатуры. В силу этой неоднородности, естественно, неизбежны и расхождения между внешнеполитическими курсами отдельных стран-участниц движения, между их позициями по тем или иным международным проблемам.

Все это активно используется империализмом. Не раз предпринимались, а в последнее время заметно активизировались попытки подорвать антиимпериалистическую сущность движения неприсоединения. Подлинная цель подобных действий-это внести раскол в отношения между неприсоединившимися странами и их естественным союзником-социалистическим содружеством, а при возможности-противопоставить их друг другу.

Основополагающие принципы движения неприсоединения воплощены в официальных документах всех его форумов. Еще в декларации Белградской встречи сказано, что прочный мир может быть обеспечен только в том случае, если с колониализмом и неоколониализмом во всех его проявлениях будет полностью покончено, что принципы мирного сосуществования являются единственной альтернативой «холодной войне» и возможной всеобщей ядерной катастрофе.

Участники VII конференции в Дели в заключительных документах еще раз заявили, что борьба против империализма, колониализма, неоколониализма, расизма и апартеида является главной задачей движения неприсоединения. Именно в этом залог его дальнейших успехов и сила движения.